

**УВС АЙМГИЙН ДАВСТ, ТАРИАЛАН СУМДЫН НУТАГТ
ОРШИХ “ЦАГААН ХӨШӨӨНИЙ АДАГ” НЭРТЭЙ ШАВРЫН
ОРДЫГ АШИГЛАЖ ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: “НЭТЭНТ” ХХК

2024 ОН

АГУУЛГА

| | |
|--|----|
| НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 2 |
| 1.1. Төслийн нэр | 2 |
| 1.2. Төслийн зорилго | 2 |
| 1.3. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл | 2 |
| 1.4. Төслийн байршил | 2 |
| 1.5. Төслийн хүчин чадал | 3 |
| 1.6. Түүхий эд, бүтээгдэхүүн | 3 |
| 1.7. Технологийн процесс, тоног төхөөрөмж | 4 |
| 1.8. Бүтээгдэхүүн гаргалт | 6 |
| 1.9. Дэд бүтэц | 6 |
| 1.10. Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдлын тооцоо | 7 |
| ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ | 8 |
| ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | |
| 3.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | 12 |
| 3.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 13 |
| ДӨРӨВ. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ, ФОТО ЗУРАГ | 18 |

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр: “Цагаан хөшөөний адаг” нэртэй шаврын ордыг ашиглаж тоосго үйлдвэрлэх төсөл.

1.2. Төслийн зорилго: Өнөөгийн мөрдөгдөж буй Монгол Улсын хууль тогтоомж, хуулийг хэрэгжүүлэх талаар гарсан дагаж мөрдөх дүрэм, журмыг мөрдлөг болгон тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглаж тоосго үйлдвэрлэх зорилготой.

“Нэтэнт” ХХК нь орон нутгийн иргэдийн урьд өмнө ашиглаж байсан ордыг гүйцээн ашиглаж, нөхөн сэргээлтийг хийх, ажлын байрыг бий болгох, орон нутагт татвар төлөх, ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг болно.

1.3. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ерөнхий мэдээлэл

Хүснэгт-1

| | |
|--|---|
| Төслийн нэр | “Цагаан хөшөөний адаг” нэртэй шаврын ордыг ашиглаж тоосго үйлдвэрлэх төсөл |
| Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын нэр, улсын бүртгэлийн дугаар, регистр | “Нэтэнт” ХХК, 1511002011, 4001621 |
| Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | MV-015576 |
| Газар ашиглах зориулалт | Тоосгоны шаврын ордыг ашиглах |
| Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ | 31.99 га |
| Төслийн байршил | Улаангом сумаас хойд зүгт 4 км зайд |
| Төлөх татвар, хураамж | Нийт улс ба орон нутгийн төсөвт оруулах хувь нэмэр 185 498 000 төгрөг |
| Ажлын байрны тоо | Нийт 36 хүн |
| Уурхайн одоогийн байдал | Шаврын ордын нөөц нь тусгай зөвшөөрлийн талбайд 2022 оны 01 дүгээр сарын 01 - ний байдлаар бодитой (В) зэргээр 242.0 мян.м ³ үлдэгдэл нөөцтэй байна. |
| Хүчин чадал | Жилд 4.0 сая ширхэг тоосго үйлдвэрлэх буюу 14 мян.м ³ шавар олборлох хүчин чадалтай. |
| Холбогдох утас | 99097107, 99452398 |

1.4. Төслийн байршил

Ашигт малтмал ашиглалтын MV-015576 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаан хөшөөний адаг” нэртэй шаврын орд нь Увс аймгийн Давст, Тариалан сумдын нутагт 31.99 га талбайг хамран оршино. Улаангом сумаас хойд зүгт Бор толгойн 2-р багийн нутагт 4 км зайд байрлана.


Тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн солбилцол

Хүснэгт-2

| № | Өргөрөг | Уртраг |
|---|---------------|---------------|
| 1 | 92° 3' 59.17" | 50° 0' 31.81" |
| 2 | 92° 3' 59.18" | 50° 0' 51.82" |
| 3 | 92° 3' 33.17" | 50° 0' 51.82" |
| 4 | 92° 3' 33.17" | 50° 0' 31.81" |

Төслийн талбайн байршил

Зураг-1



1.5. Төслийн хүчин чадал

“Цагаан хөшөөний адаг” нэртэй шаврын ордын нөөц нь бодит В-зэргийн нийт нөөц 242 мян.м3 үйлдвэрлэлийн магадласан В нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нийт 107 мян.м3 тоосгоны шавар олборлохоор байна. Үйлдвэрийн энэхүү нөөцийг олборлохын тулд 6 мян.м3 хөрс хуулалт хийхээр ТЭЗҮ-д тооцжээ. Жилд 4 сая ширхэг тоосго үйлдвэрлэх буюу 14 мян.м3 тоосгоны шавар олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг бүрэн ашиглахад 8 жил шаардагдахаар байна.

1.6. Түүхий эд, бүтээгдэхүүн

Ордын түүхий эд (шавар), болон бүтээгдэхүүнд (шавар) хайгуул болон ашиглалтын үед холбогдох шинжилгээнүүдийг Геологийн төв лаборатори, БАК-ын лаборатори, МУИС-ын цацрагийн лабораториудад хийлгэсэн. Мөн жил бүр Увс аймгийн

газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын материалын сорилт шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторид тоосгоны физик механикийн шинжилгээг хийлгэж ирсэн байна. Олборлосон шаврыг, шигшиж бутлан, зуурч хэвлэж, түүхий тоосгыг бааюунд шатаан жилд 4.02 сая ширхэг MNS-2513-99-ын шаардлагыг хангасан тоосго үйлдвэрлэнэ.

1.7. Технологийн процесс, тоног төхөөрөмж

Тоосго үйлдвэрлэх шавар нь хүлээн авах бункерт орон, туузан дамжлагаар анхны бутлагчаар дамжин, том хэмхдэсийг ялгах торон эргэлтэт шигшүүрээр шигшигдэж нэмэгдэл хольцын хамт (нүүрс, ус) холигч болон шахагч (пресс), хэрчигч дамжлагуудаар дамжин түүхий тоосго болон гарна. Тоосго нь 60мм*120мм*240мм хэмжээтэйгээр хэрчигдэн хүлээн авах дамжлагаар дамжин тэдгээрийг жижиг оврын тээврийн хэрэгслээр тээвэрлэн хатаах талбайд хүргэнэ. Хатаах талбайд түүхий тоосгыг хураан байрлуулж, хур тунадас, салхины нөлөөллөөс хамгаалах арга хэмжээ авч 2-3 хоногийн хугацаанд хатаасны дараа шатаах баюуд оруулан эцсийн бүтээгдэхүүн болгоно.

Тоосго үйлдвэрлэх үндсэн шат дамжлагын дэс дарааллыг дараах схемээр үзүүлэв.

Тоосго үйлдвэрлэх ерөнхий дамжлага

Зураг-2



Шавар боловсруулалт

1. Шигшүүр: Шигших дамжлага нь технологийн эхний дамжлага бөгөөд шигших үүрэг бүхий 2 янзын нүхтэй торыг хуйлж хийсэн шигшүүр байна.

2. Бутлуур: Шигшүүрээс гарсан шаврыг бутлах энгийн бутлагч байна. Хоорондын зай 2см.

3. Тээрэм: Бутлуураас гарч ирэх шаврыг жигд нунтаглах буюу шаврыг зуурмагт бэлтгэх 0,5см-ын зайтай нунтаглах төхөөрөмж байна.

4. Зуурагч: 2 эгнээ сэнсэн хэлбэртэй зуурагч нь шавар ба нүүрсийг жигд хольж зуурах ажиллагааг хийнэ.

Тоосго хэвлэх

1. Хэвлэх пресс: Бэлэн болсон зуурмагыг вакуум аргаар агааргүй орчинд хүчтэй даралтаар шахаж гаргах төхөөрөмж юм.

2. Хэрчигч: Хэвлэх прессээр шахагдан гарч ирсэн шаврыг тоосго хэлбэрт оруулан зүсэх зориулалт бүхий төхөөрөмж.

Тоосго таслагч

Зураг-3



Тоосго хатаах

1. Технологийн хэвлэх дамжлагаар бэлэн гарч ирсэн тоосгыг ул модонд өрж хатаах талбайд зөөвөрлөж хүргэнэ.

2. Тоосгыг цаг агаарын байдлаас шалтгаалж 10-14 хоногийн хугацаанд хатаана.

Тоосго шатаах

Хатаасан тоосгыг шатаах зууханд өрж шатаана. Шатаах зуух нь амтай нэг талаараа явдаг дугуй зуух. Хатсан улаан тоосгоо зуухандаа өрнө. Бүрэн өрсний дараа хатаалт, хөргөлт, шатаалт гэсэн 3 өөр галаа оруулна. Галлаж эхэлсэний дараа шатааж дууссан тоосгоо гаргаад өрж явуулна.

Тоосго шатаах зуух

Зураг-4



1.8. Бүтээгдэхүүн гаргалт

Тоосгоны үйлдвэр нь жилд 13.88 мян,м³ шавар олборлож 4.0 сая.ширхэг тоосго үйлдвэрлэнэ. Бэлэн бүтээгдэхүүн 1000 ширхэг тоосго үйлдвэрлэхэд нормоор 0.5 тн үнс, тоосго шатаахад 0.2 тн нүүрс тус тус орно. Тоосгоны зуурмаг зуурах усны хэрэглээ 1000 ширхэг тоосго үйлдвэрлэхэд 125л ус хэрэглэгдэх нормыг үндэслэж жил бүр зарцуулах усны хэмжээг тодорхойлсон болно. Эндээс нэг жилд шаардагдах үнс, нүүрсний хэмжээ, гарах зардлыг тооцож хүснэгт-3-т үзүүлээ.

Тоосгонд орох нэмэлт орц

Хүснэгт-3

| Үзүүлэлт | 1000 ширхэг тоосго үйлдвэрлэх норм | |
|--------------------------|------------------------------------|---------------|
| | 0.5 тн, үнс | 0.2 тн, нүүрс |
| Жилийн хэрэглээ, тн | 20000 | 800 |
| Худалдаж авах зардал,төг | 13,940.0 | 32,800.0 |

1.9. Дэд бүтэц

Үйлдвэрийн усан хангамж

Тоосгоны үйлдвэрийн унд ахуйн хэрэглээний ус болон ногоон байгууламж, үйлдвэрийн технологийн усанд 261.6м³/хон ус зарцуулагдахаар байна. Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн эзэмшлийн 4.2 л/с ундаргатай гүний худгаас хангана. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг 2023 онд “Усны газар”-аар гаргуулсан. Төслийн жилийн усны хэрэглээг 2015 онд БОНХАЖ-ын сайдын А/301 тоот тушаалаар батлагдсан нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын дагуу тооцоолов.

Унд ахуйд 36 хүн х 50л= 1.8м³/хон (239.4м³/жил)

Технологийн усны хэрэглээнд $40000 \text{ ш} \times 0.8 \text{ м}^3 / \text{хон} = 240.6 \text{ м}^3 / \text{хон}$ (32000м³ /жил)

Ногоон байгууламж услах усны хэмжээ нормын 13-р хавсралтын дагуу дараах байдлаар тооцоолов. Үүнд: $43000 \text{ м}^2 \times 4 \text{ л} = 17.2 \text{ м}^3 / \text{хон}$ (422м³/жил) Зам талбайн тоосжилт дарахад $10000 \text{ м}^2 \times 2 \text{ л} = 2 \text{ м}^3 / \text{хон}$ (160м³/жил). Нийт 261.6 м³ /хон (32812м³ /жил) ус шаардагдана. Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 261.6 м³ /хон усны хэрэгцээг 4.2 л/с (363 м³ /хон) ундаргатай худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

Уурхайн цахилгаан хангамж

Тоосгоны үйлдвэрийн талбайд байрлах 10 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаас буулгасан 10/0.4 кВ-ын трансформатораас хүчдэл авдаг тул эрчим хүчний хангамжийн асуудал бүрэн шийдэгдсэн.

1.10. Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдлын тооцоо

Хог хаягдал Төсөл хэрэгжүүлэгч нь ахуйн гаралтай хог хаягдлыг “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ -тай байгуулсан “Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ” байгуулан зайлуулж байна.

Хатуу хог хаягдал

Тухайн төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу хог хаягдлыг үйлдвэрлэлийн хог хаягдал ба энгийн ахуйн хог хаягдал гэж 2 хувааж үзэж болно.

Үйлдвэрийн хог хаягдал: “Нэтэнт” ХХК-ийн шавар олборлон тоосго үйлдвэрлэх үйл явцад үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүн гарахгүй. Гэвч түүхий тоосгыг шатаахаас өмнө технологийн болон байгалийн нөхцөлд хатаах явцад тоосго хагарч эвдрэн хаягдал гарах явдал байна. Үүнийг цуглуулан эргээд шаварт хольж түүхий эд болгон ашигладаг. Ийм тохиолдолд хог хаягдал гэж үзэхгүй. Мөн бааюунд түүхий тоосгыг шатааж гаргах болон хураах, тээвэрлэх явцад бэлэн болсон тоосго хагарах, хэмжээ алдагдах байдал ажиглагдаж болно. Үүнийг орон нутагт хямд үнээр борлуулдаг.

Харин бүр жижиг хэлтэрхийнүүдийг тусгай талбайд цуглуулан сумын нэгдсэн хогийн цэгт зайлуулна. Үүний хэмжээ нийт бүтээгдэхүүний 0.01 хувийг эзлэхээр байна.

Энгийн хог хаягдал: Энгийн хог хаягдлын дийлэнх хувийг ахуйн хог хаягдал бүрдүүлнэ. Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаягдлууд болох хоол хүнсний үлдэгдэл, бараа материалын сав баглаа боодол, цаас, шил, сав, хэмхэрхий эд хогшил, пластмасс, төмөр, шил, яс, мод зэрэг хог хаягдлууд орно.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

“Цагаан хөшөөний адаг” нэртэй шаврын ордын олборлолтын үйл ажиллагаанаас 8.1 га, шимт хөрсний овоолго 0.1 га, зам 1.1 га талбай хүчтэйгээс бага зэргийн нөлөөлөлд өртөж эвдрэлд орно. Эдгээр эвдрэлд орох талбайн үржил шимт хөрсийг тусгайлан 0.2 м хүртэлх зузаантайгаар хуулж шимт хөрсний түр овоолгод хадгалахаар тооцсон.

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл:

- Шаврын ордын ил уурхай, овоолго, зам болон бусад байгууламжуудаар газрын гадаргын хэлбэр дүрс нэмж өөрчлөгдөх;
- Ил уурхайн ухаашаас газрын хэвлийг эвдэх;
- Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал амьтанд аюултай байдал үүсэх;
- Шаврын ордын ил уурхай, тоосгоны үйлдвэрийн хэсэг, агуулах зэрэг объектуудад өртөх эдэлбэр газар ашиглалтаас хасагдах зэрэг сөрөг нөлөөтэй.

Төслийн талбай нь хөрс газарзүйн мужлалаар Алтайн умардын өндрийн бүсшийн 55-р тойрогт багтана. Хөрсний шинжилгээний үр дүнгээр сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, бага зэргийн давсжилттай, хөрсний шим тэжээлийн бодис болох хөдөлгөөн фосфор болон калийн хангамжаар дундаас доош үзүүлэлттэй байна.

Талбайн хөрсний сүлжээний зураг

Зураг-5




Ургамал газарзүйн мужлалаар олон нуурын цөлөрхөг хээрийн бүсэд хамаарах бөгөөд ургамлын хэв шинжээрээ цөлөрхөг хээрийн ургамал зонхилно. Тус талбайн ургамлан нөмрөгийн бүрхэвч Улалж хиаг дэрст, дэрс хиагт бүлгэмдэлт бэлчээр талбайн зүүн хэсэгт нилээд чийглэг газраар нугын мараалаг хужирлаг карбонатлаг хөрстэй

газраар тохиолдоно. Улалж хиаг дэрст бэлчээр бэлчээрийн ангилалаар сайн чанарын бэлчээрт хамрагддаг. Энэ бэлчээр нь бүх төрлийн малд тохирно.

Талбайн ургамлын хэв шинжийн зураг

Зураг-6




Төслийн нийт үйл ажиллагаанаас Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн сайдын 2014 оны 4 сарын 10-ны А-117-р тушаалаар “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тогтоох, түүний тооцооллыг хийх аргачлалыг тус аргачлалын 3-р хэсэгт заасны дагуу нөлөөлөл буурах функц ашиглан нөлөөллийн эрчим, орон зай, цаг хугацааны тархалтыг давхцуулан зураглахад төсөл хэрэгжих талбайгаас 300м радиуст нөлөөллийн эрчим 284 га хүчтэй, 500м радиуст нөлөөллийн эрчим 645 га дунд 800 м-т радиуст 146.1 га нөлөөллийн эрчим бага буюу аажмаар буурч байна. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол агаар бохирдуулагч болох тоос, тоосонцрын орчинд нөлөөлөх, нөлөөллийн цар хүрээг AERMOD VIEW 8.9.0 программ хангамж ашиглан тооцоход:

Уурхайн ухааш. Уурхайн олборлох үйл ажиллагаа буюу хөрс, хуулалт ачиж тээвэрлэх, ухах зэргээс үүсэх тоосжилт гол тоосонцрын эх үүсвэрүүд юм. Ухааш олборлолтоос үүсэх нийт тоосжилт шаврын ордын уурхайн бүсэд орчны төвшинг жилийн дундаж агууламжийг 0.9-46 мкг/м³, PM10 тоосонцор 0.6-61.6 мкг/м³ нэмэгдүүлж байна.

Уурхайн нийт үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт. Уурхайн бүх эх үүсвэрээс үүсэх агаар бохирдуулагчийн орон зайн тархалтаас үзэхэд уурхайн бүсэд буюу шавар олборлолт тээвэрлэлт явагдаж байгаа хэсэгт нийт тоосонцрын жилийн дундаж агууламж 0.6-61.6 мкг/м³ байна. Уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа хүрээнээс гадна уурхайгаас үүсэх тоос, тоосонцорын хэмжээ агаарын чанарын стандартын хэмжээнд байна.


Ухаш олборлолтоос үүсэх PM10 тоосны жилийн дундаж агууламжийн тархалт, мкг/м³

Зураг-7




Ил уурхайгаас овоогоос үүсэх TSP тоосны жилийн дундаж агууламжийн тархалт, мкг/м³

Зураг-8



Ухаш олборлолтоос үүсэх PM10 тоосны жилийн дундаж агууламжийн тархалт, мкг/м3

Зураг-9



Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд төслийн үйл ажиллагааны зүгээс үзүүлэх нөлөөллийг матрицын болон магадлан жагсаах аргаар нийт 43 нөлөөллийг тооцсон.

Тэдгээр нөлөөлүүдийн 8 буюу 36% нь бага, 7 буюу 28% нь дунд, 5 буюу 23% нь их байгаа бол 3 буюу 12% нь маш их нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Увс аймгийн Давст, Тариалан сумын нутагт орших “Цагаан хөшөөний адаг” нэртэй тоосгоны шаврын ордыг ашиглаж тоосго үйлдвэрлэх төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч “Нэтэнт” ХХК-ийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

3.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь “Цагаан хөшөөний адаг” нэртэй тоосгоны шаврын ордыг ашиглаж тоосго үйлдвэрлэх төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж төсөл хэрэгжүүлэгч “Нэтэнт” ХХК-иас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, бусад холбогдох хуулиуд, дүрэм, журам болон БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй. Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн “Нэтэнт” ХХК-иас “Цагаан хөшөөний адаг” төслийг хэрэгжүүлэхэд зориулагдсан болно. Төслийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, агаар, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай. БОХТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр

дүнгүүдэд үндэслэн хийх, БОХТ-ний биелэлтийг дүгнэхдээ жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх ёстой. БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 01-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын болон газрын доорх усны нөөц хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Аймгийн БОАЖГ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

Улирлын чанартай ажилладаг уурхайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг талбай дээр бодитоор нь үнэлэх, хэмжилт хийх боломжтой нөхцөлд зохион байгуулна.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр: Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчны болон ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийж шинэчлэн тооцно.

3.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-4

| № | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөлт | Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл | Ажлын биелэлт |
|--------------------|---|--|---------------|
| Агаар орчин | | | |
| 1 | Уурхайн үндсэн машин механизм- 4 ш, бусад машин-5ш жилд дунджаар 118 тн түлш ашиглана. Жилд 36 кг хорт хий ялгарахаар байна. Засвар үйлчилгээг тогтмол хийх, үзлэг оншилгоонд оруулах | Нийт тээврийн хэрэгслийг тогтмол хугацаанд үзлэг оншилгоонд хамруулж, засвар үйлчилгээ хийж ажилласан. | 100% |
| 2 | Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ. | | 100% |


| | | | |
|-----------------------|--|--|------|
| | Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавина /TWCAT002,TWCAT0061 маркийн шүүлтүүр/ | | |
| 3 | -Нарийн ширхэгт тоос барих шүүгч байршуулах; -Шатаах зууханд агааржуулагч байршуулах, хяналтын мэдрэгчүүд суурьлуулж тогтмол хяналт тавьж ажиллах; | Тогтмол хяналт тавьж ажилласан. | 85% |
| 4 | Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах, тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS- ийн мэдээнд хяналт тавих; | Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулсан бөгөөд GPS-г 2025 оны БОМТ-нд тусгаж хэрэгжүүлнэ. | 50% |
| 5 | Тоосжилтыг дарах зорилгоор авто зам, уурхайн карьерийн мөргөцөг, шимт хөрсний овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаанд ус ашигласны төлбөр төлөх | Ордоос тоосгоны завод хүртэл 3км замыг 1 өдөрт дунджаар 8 тонн ус ашиглан цацаж тоосжилтыг дарж ажилласан. Тоосжилт дарах усны зардал нь 80.000×16 удаа буюу нийт 1,280,000.0 төгрөг болсон | 100% |
| 6 | Хог хаягдал болон үнс тээвэрлэхдээ асгарах, тоосрохоос хамгаалсан хучлагатай байх; | Тогтмол хяналт тавьж ажилласан. “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын захиралтай 2024 оны 05-р сарын 17-ны өдөр Хог тээвэрлэх гэрээ байгуулан гэрээний дагуу ажилласан. Хог хаягдлын төлбөрт 350,000.0 төгрөг төлсөн. | 100% |
| Хөрсөн бүрхэвч | | | |
| 7 | Хатуу хог хаягдал, ахуйн хог хаягдлыг эмх цэгцтэй хадгалах, төвлөрсөн хогийн цэгт хүргэх; | Тогтмол хяналт тавьж ажилласан. “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын захиралтай 2024 оны 05-р сарын 17-ны өдөр Хог тээвэрлэх гэрээ байгуулан гэрээний дагуу ажилласан. Хог хаягдлын төлбөрт 350,000.0 төгрөг төлсөн. | 100% |
| 8 | -Нам доор хотгор, хуучин голын сайр бүхий газар учир далан, хамгаалалт, ус зайлуулах суваг зэргийг иж бүрэн хийх, тогтмол засах, засварлах; -Авто засварын газар, ШТС, тээврийн хэрэгслийн зогсоол зэрэг нөлөөлөлд өртөх ил хөрстэй талбайг хатуу хучилттай болгох, машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших, урсгал засварын ажлыг тогтмол; -Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс хучилтгүй замын гадаргууг засах; -Уурхайн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлнэ; | Тогтмол хяналт тавьж ажилласан. Орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулж иргэдийн гаргасан саналын дагуу иргэд зорчих замд шороо асгаж замын засаж өгсөн болно. Үйлдвэрийн хашаанд болон 500м зайн орчны бүсэд хавар 05 сард , намар 10 сард их цэвэрлэгээний ажил хийсэн. | 90% |
| Гадаргын ус | | | |
| 9 | Тухайн жилийн ус ашиглах дүгнэлтийг жил бүр эрх бүхий байгууллагаар гаргуулах, ашиглах усны эх үүсвэрийг тоолуураар баталгаажуулж, тоолуурын заалтаар усны төлбөрийг цаг хугацаанд нь төлж байх. Ус ашиглалтын гэрээг | Увс нуур-Тэс голын сав газрын захиргаанаас 2024 оны 02-р сарын 29-ний өдөр 04 дугаартай Ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан. Аймгийн БОАЖГ-тай 2024 оны 03- | 100% |

| | | | |
|-----------------------------------|---|--|------|
| | орон нутгийн болон бусад холбогдох байгууллагатай хийнэ. Усны нөөц ашигласны төлбөрийг тогтсон хугацаанд нь төлнө. | р сарын 01-ний өдөр 04 дугаартай Ус ашиглах гэрээ байгуулсан. Усны төлбөрт 619,750.0 төгрөг төлсөн. | |
| Ургамлан бүрхэвч | | | |
| 10 | Стандартын дагуу нөхөн сэргээлтийн арга хэмжээ авах; | 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 8,000,000.0 төгрөг зарцуулсан. | 100% |
| 11 | Тухайн орчинд хамгийн сайн ургах чадвартай мод бут сөөг болон таримал олон наст ургамлыг стандартын дагуу тариалах; | Улаангом сумын засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Улаангом сумын 4-р багийн нутаг дэвсгэрт мэргэжлийн байгууллагаар 200ш бургас, 200ш улиас мод тариулж байна. | 100% |
| Амьтны аймаг | | | |
| 12 | Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх; | Мод тарих үндэсний өдөр болон Дэлхийн усны өдөрт зориулж Сумын ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улаангом сумын засаг даргатай гэрээ байгуулж 4 багийн цэцэрлэгт хүрээлэн мод тарих үйл ажиллагаанд 1,000,000 төгрөгний дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Цаашид орон нутагтай хамтран ажиллана. | 100% |
| 13 | Хог хаягдлын битүү зориулалтын цэг байгуулах, тогтмол ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх, хог хаягдлын гэрээний дагуу ажиллах; | Эрх бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт, шавж устгал, мэрэгч устгалын ажил хийлгэсэн. | 100% |
| ХАБЭА хүрээнд хийгдэх ажил | | | |
| 14 | Дуу шуугианы хэмжилт | Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор агаарын чанарын хэмжилт хийлгэсэн. | 50% |
| 15 | Шаврын ордын уурхай, тоосгоны үйлдвэрийн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, яаралтай тусламжийн эмийн санг бүрдүүлж, байрлуулж бүрэн бүтэн байдал, тоног төхөөрөмж, багажны хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах; | 2024 оны 05-р сард нийт ажилчдыг Аймгийн төв эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Тоног төхөөрөмж, багажны хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажилладаг. | 100% |
| 16 | Ажлын онцлогт тохирсон ажлын хувцас хамгаалах хэрэгслээр хангах; | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны 50 ширхэг хувцас олгосон. | 100% |
| Дүйцүүлэн хамгаалах | | | |
| 17 | Байгаль орчны сургалт зохион байгуулах, хөв цөөрөм байгуулах газрын судалгаа хийх, хөв цөөрөм байгуулах, арчилгаа тордолтын ажлыг гүйцэтгэх орон нутагтай гэрээ байгуулах; | Мод тарих үндэсний өдөр болон Дэлхийн усны өдөрт зориулж Сумын ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд | 50% |


| | | | |
|--|--|---|------|
| | | Улаангом сумын засаг даргатай гэрээ байгуулж 4 багийн цэцэрлэгт хүрээлэн мод тарих үйл ажиллагаанд 1,000,000 төгрөгний дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Цаашид орон нутагтай хамтран ажиллана. | |
| 18 | Сум орон нутагтай хамтран тухайн орчинд хамгийн сайн ургах чадвартай мод бут сөөг болон таримал олон наст ургамлыг стандартын дагуу тариалах; | Улаангом сумын засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Улаангом сумын 4-р багийн нутаг дэвсгэрт мэргэжлийн байгууллагаар 200ш бургас, 200ш улиас мод тариулж байна. | 100% |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | | | |
| 19 | Агаарын чанарын хэмжилт хийлгэх; | Төслийн талбайгаас агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усны дээж авч Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторт шинжилгээнд хамруулсан. | 100% |
| 20 | Хөрсний дээж авч шинжилгээнд хамруулах; | | 100% |
| 21 | Усны дээж авч шинжилгээнд хамруулах; | | 100% |
| Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | | | |
| 22 | -Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгээ сумын засаг даргаар тогтоолгоно. -Хатуу хог хаягдлыг түр хадгалах цэгийг барих, хогийн савуудыг байршуулах; | “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын захиралтай 2024 оны 05-р сарын 17-ны өдөр Хог тээвэрлэх гэрээ байгуулан гэрээний дагуу ажилласан. Хог хаягдлын төлбөрт 350,000.0 төгрөг төлсөн. Хог хаягдлыг ангилан ялгадаг бөгөөд цаашид хог хаягдлын цэгийг засаж сайжруулна. | 70% |
| 23 | -Хатуу хог хаягдлыг ангилан 2 догч түүхий эд авах газарт хүргэх. Жишээ нь аккумулятор, хуруу зай, машины дугуй, хуванцар сав; -Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх; | Аккумулятор, хуванцар сав зэргийг хоёрдогч түүхий эд авдаг газарт хүргүүлдэг. Автомашин дугуйг дотоод үйл ажиллагаандаа ашиглаж байна. Ажилласан тос маслыг орон нутагт газар тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж ирж авдаг. | 80% |
| 24 | -Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх; | Цаашид сургалт явуулж, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөнө. | 40% |
| 25 | | | |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | | | |
| 26 | -Байгаль орчныг хамгаалах талаар сургалтуудыг жилд нэг удаа зохион байгуулах, Аймгийн БОАЖГ-ын холбогдох мэргэжилтэн, алба хаагчидтай харилцан холбоотой ажиллах; -Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах; | Аймгийн БОАЖГ-ын холбогдох мэргэжилтэн, албан хаагчидтай харилцан холбоотой ажиллаж Байгаль орчныг хамгаалах тухай хууль, дүрэм журам стандартын дагуу Байгаль орчныг хамгаалах | 100% |

| | | | |
|----|---|--|------|
| | | сургалтанд хамрагдсан. | |
| 27 | Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг биелүүлэх; | “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын захиралтай 2024 оны 05-р сарын 17-ны өдөр Хог тээвэрлэх гэрээ байгуулан гэрээний дагуу ажилласан. Хог хаягдлын төлбөрт 350,000.0 төгрөг төлсөн. | 100% |
| 28 | Халдваргүйжүүлэлт, шавж устгал, мэрэгч устгал хийлгэх; | Эрх бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт, шавж устгал, мэрэгч устгалын ажил хийлгэсэн. | 100% |
| 29 | Үйлдвэрийн хашаанд болон орчны бүсэд (500м зайд) хавар, намрын их цэвэрлэгээ хийх; | Үйлдвэрийн хашаанд болон орчны 500 м зайд хавар 05 сард, намар 10 сард их цэвэрлэгээний ажил хийсэн. | 100% |
| 30 | - Мод тарих үндэсний өдөр болон Дэлхийн усны өдөрт зориулж байгаль орчныг хамгаалах чиглэлийн байгууллагуудтай хамтран ажиллах; - “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих; | Улаангом сумын засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Улаангом сумын 4-р багийн нутаг дэвсгэрт мэргэжлийн байгууллагаар 200ш бургас, 200ш улиас мод тариулж байна. | 100% |
| 31 | Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулж батлуулах; | Жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайлан боловсруулж батлуулан ажиллаж байна. | 100% |
| 32 | Орон нутгийн иргэдтэй нээлттэй уулзалт зохион байгуулах, иргэдийн зүгээс гаргасан саналыг хэрэгжүүлэх талаар дотоод төлөвлөлт хийх; | Орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулж иргэдийн гаргасан саналын дагуу иргэд зорчих замд шороо асгаж замын засаж өгсөн. | 100% |


Техникийн нөхөн сэргээлт хийсэн 5 га талбайн фото зураг



Увс нуур-Тэс голын сав газрын захиргаанаас 2024 оны 02-р сарын 29-ний өдөр 04 дугаартай Ус ашиглуулах дүгнэлт



Аймгийн БОАЖГ-тай 2024 оны 03-р сарын 01-ний өдөр 04 дугаартай Ус ашиглах гэрээ



3.1.13 Ус ашигласны болон түгээмэл тархцатай ашигт малтмал ашигласны төлбөр хураангуйн кагас бүтэн жилээр төсөвт барагдуулах

3.1.14 Энэ гэрээний биелэлтийн тайланг жил эцэсээр гаргаж сумын Засаг даргад ирүүлэх.

Дөрөв. Гэрээний хэрэгжилт

- 5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ахсын 3 хоногийн дотор байрлуулна. Гэрээний хуудас ахсын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүргэ)-ийн Онборлогч үйлдвэрлэлийн ил тод байдлын саналчилгын дэд мөнгөнд хүргүүлнэ.
- 5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг (нийслэл), сум (дүүргэ)-ийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.
- 5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологч, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Тав. Гэрээний хариуцлага

- 6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээ татгалзах үндэслэл болохгүй.
- 6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг төсгөлн , уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцонд хүчн чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох



Улаангом сумын засаг даргатай байгуулсан гэрээ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

2024.10.01

Улаангом

Энэхүү гэрээг нэг талаас Үвс аймаг(нийслэл) Улаангом сум (дүүрэг)-ын Засаг дарга Ц.Гантөмөр (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас түгээмэл тархацтай малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Нэтэнт ххк (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 10-р сарын 01-ны өдөр Үвс аймаг (нийслэл) Улаангом сум (дүүрэг)-нд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Үвс аймаг Улаангом сум (дүүрэг)-ын 2-р багийн нутагт Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны хамгаалах, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын байгаль орчныг хамгаалах, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмал эрх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.3. энэхүү гэрээний хэрэгжилтэй холбоотой уулзалт, халалцурлаг зохион байгуулж, аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих;

2.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх .

2.1.7. түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулахад сум орон нутгийн засаг захиргааны зүгээс холбоотой ажил, бичиг баримтуудыг цаг харгалзахгүйгээр тухай бүр нь саадгүй үйлчлэх.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.1.4. өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;

3.1.5. хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг) –ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

3.1.6. бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.1.7. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.8. гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг тусалцаа үзүүлэх.

3.1.9. Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 3.1.7 дахь заалтыг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах

3.1.10 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тусгай зөвшөөрлийн ашиглалтын талбайд хамгаалалтын зурвас байгуулах

3.1.11 Сумын ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4 багийн цэцэрлэгт хүрээлэн мод тарих үйл ажиллагаанд 1,000,000 (нэг сая) төгрөгний дэмжлэг үзүүлж хамтран ажиллах

3.1.12 Тээвэрлэлт хийх замын эвдрэл гэмтлийг засаж сайжруулах, замын тоосжилтийг багасгах арга хэмжээ авч тээвэрлэлтийг хийх

- 8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.
- 8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
- 8.4. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ,
УВС АЙМАГ, УААНГОМ СУМЫН
ЗАСАГ ДАРГА
.....Ц.ГАНТӨМӨР /

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ
АШИГТ МАЛТМАЛЫН
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ
НЭТЭНТ ХХК-НИЙ
ЗАХИРАЛ
/А ХИЛЭНБААТАР/



“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-тай байгуулсан Хог хаягдал тээвэрлэх гэрээ



ХОГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 05 -р сарын 17. өдөр

№.....

Улаангом

Нэг: Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ –ыг төлөөлж Хог хаягдал хариуцсан мэргэжилтэн **Өлзий** овогтой **Бэгзсүрэн** нөгөө талаас *Нэгэнлт ХХК* байгууллагыг төлөөлж *Алгалах* овогтой *Шинэбаатар* /РД: *Т.Т.Т.101.2025* / нар нь Монгол улсын “Хог хаягдлын тухай хууль” –ийн 10 -р зүйлийн 10.2.3 заалтыг үндэслэн тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа: **2024 оны 05 сарын 17** –ний өдрөөс **2025 оны 06 сарын 17** –ний өдөр хүртэл

Хоёр: Аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг хариуцлага

- 2.1 Ажил үйлчилгээ хөнгөн шуурхай болгох үүднээс хуурай хог хаягдал, үнсээ тусгай саванд савлаж тавьсан байх.
- 2.2 Ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд сард *35000* төгрөгийг, жилд / *350000* / - төгрөгөөр саадгүй төлж байх.
- 2.3 Хог тээвэрлэх машины хуваарьт цагийг алдагдуулж чирэгдэл учруулахгүй байх. *10 машин*

Гурав: “УТҮ” ОНТҮГ –ын хүлээх үүрэг

- 3.1 7 хоногт 3-аас доошгүй удаа хог хаягдлыг авах
- 3.2 Ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд сард *35000* төгрөг, жилд *350000* төгрөгөөр тооцон **Хас банкны 5002836341 (Улаангом тохижилт үйлчилгээ УТҮГ)** тоот дансанд хийх
- 3.3 Хог ачих хуваарийн дагуу машин техникээ саадгүй ажиллуулах.

Дөрөв: Бусад зүйл

- 4.1 Гэрээнд заасан үүргээ 2 тал сахин биелүүлэх
- 4.2 Гэрээг биелүүлэхээс татгалзвал хог тээвэрлэх боломжгүй гэж үзэн хуваариас хасах.
- 4.3 Зөрчлийн улмаас гэрээнд тусгагдсан нөхцөлөөс бусад шалтгаанаар үүссэн хог хаягдлыг буруутай этгээд өөрсдийн зардлаар тээвэрлэх болно.

“Улаангом тохижилт үйлчилгээ”
ОНТҮГ -ыг төлөөлж
.....
ХХХМэргэжилтэн
..... *Бэгзсүрэн* / Ө.Бэгзсүрэн /
Утас 7045-4789, Гар утас: 90729092



Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн шинжилгээний хариу



УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН

Утас: 7445-3680
Утас: 7445-3680

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар он / код №: 2024/018
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "Нэгтэн" ХХК-ны төсөлгөөний үйлдвэр
Сорьц авсан хувийн нэр, албан тушаал: Ж.Сүлд-Эрдэнэ, шинэсэн
Сорьцны хэмжээ, төрөл: мкг/л
Сорьцныг авсан өдөр: 2024.06.05
Шинжилгээний аргын стандарт: MNS,
Лабораторид өрсөн: 2024.06.05
Шинжилгээ хийсэн өдөр: 2024.06.05
Хуудасны тоо: 1/1
Үр дүн:

| Шинжилгээний аргын стандартууд | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжээний нэгж | Хувиар агуулам, MNS 4585.2016 | Шинжилгээний үр дүн |
|--------------------------------|---|-------------------------------|---------------------|
| MNS 17.2.5.12.2021 | Хүхрүүлж хий - SO ₂ , мг/м ³ | 0.450 | 0.007 |
| MNS 17.2.5.11.2021 | Алтын давхар исэл - NO ₂ , мг/м ³ | 0.200 | 0.064 |
| MNS 4248-88 | Тоос - нэгт, мг/м ³ | 0.500 | 0.029 |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Ж.Сүлд-Эрдэнэ (нэр)
Хянаж баталгаажуулсан чанарын зөвшөөрөгч: Т.ОЮУНММӨГ (нэр)

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн сорьцонд хамаарна. Шинжилгээний дүнг лабораторийн эвчээрлэлтэй хуулбартай хэрэглэнэ.



УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН

Утас: 7445-3680
Утас: 7445-3680

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар он / код №: 2024/017
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "Нэгтэн" ХХК-ны төсөлгөөний үйлдвэр
Сорьц авсан хувийн нэр, албан тушаал: Ж.Сүлд-Эрдэнэ, шинэсэн
Сорьцны хэмжээ, төрөл: мкг/л
Сорьцныг авсан өдөр: 2024.06.05
Шинжилгээний аргын стандарт: MNS,
Лабораторид өрсөн: 2024.06.05
Шинжилгээ хийсэн өдөр: 2024.06.05-06.07
Хуудасны тоо: 1/1
Үр дүн:

| Шинжилгээний аргын стандарт | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжээний нэгж | Шинжилгээний үр дүн |
|-----------------------------|---|---------------------|
| MNS 3310:1991 | Орчин - рН | 7.98 |
| | Давсгалт - ЕС у/б/м | 515.0 |
| | Чийр - % | 0.60 |
| | Влага | 5.6 |
| | Амьсгал - NH ₄ , мг/л | 22.0 |
| MNS 6838:2020 | Нитрат - NO ₃ , мг/л | 50.3 |
| | Сулфат - SO ₄ , мг/л | 956.4 |
| | Фосфат - P ₂ O ₅ , мг/л | 7.1 |
| | Хөрсөн дэх нефтийн бүтэцдээгүй, мг/л | 0.1 |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Ж.Сүлд-Эрдэнэ (нэр)
Хянаж баталгаажуулсан чанарын зөвшөөрөгч: Т.ОЮУНММӨГ (нэр)

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн сорьцонд хамаарна. Шинжилгээний дүнг лабораторийн эвчээрлэлтэй хуулбартай хэрэглэнэ.



УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН

Утас: 7445-3680
Утас: 7445-3680

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар он / код №: 2024/019
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "Нэгтэн" ХХК-ны төсөлгөөний үйлдвэр
Сорьц авсан хувийн нэр, албан тушаал: Ж.Сүлд-Эрдэнэ, шинэсэн
Сорьцны хэмжээ, төрөл: ус
Сорьцныг авсан өдөр: 2024.06.05
Шинжилгээний аргын стандарт: MNS,
Лабораторид өрсөн: 2024.06.05
Шинжилгээ хийсэн өдөр: 2024.06.05-07
Хуудасны тоо: 1/1
Үр дүн:

| Шинжилгээний аргын стандартууд | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжээний нэгж | Хувиар агуулам, MNS 900:2018 | Шинжилгээний үр дүн |
|--------------------------------|--|------------------------------|---------------------|
| MNS 6838:2020 | Нитрат - NO ₃ , мг/л | 0.5-8.0 | 7.98 |
| MNS 150:7868:1999 | Шинжилсэн давсгалт чанар - ЕС, у/б/м | 1000 | 299.0 |
| MNS 6833:2020 | Перманганатын исэлдэх чанар - рН ₂ , мг/л | | 0.6 |
| MNS 1097:2023 | Амьсгал - NH ₄ , мг/л | 1.5 | 0.19 |
| MNS 4431:2006 | Нитрат - NO ₃ , мг/л | 1.9 | 0.319 |
| MNS 6834:2020 | Нитрат - NO ₃ , мг/л | 50.0 | 0.82 |
| MNS 9271:2010 | Сулфат - SO ₄ , мг/л | 500.0 | 48.8 |
| MNS 150:6878:2001 | Фосфат - PO ₄ , мг/л | 3.5 | 0.208 |
| MNS 4430:2005 | Тамар - Fe, мг/л | 0.3 | 0.09 |
| MNS 8272:2011 | Фосф - P, мг/л | 0.7-1.5 | 0.34 |
| MNS 4424:2005 | Хлор - Cl, мг/л | 350.0 | 12.7 |
| MNS 1097:2023 | Мягц - Mg, мг/л | 30.0 | 13.1 |
| MNS 6178:2019 | Хатуулаг, мг/л | 7 | 3.08 |
| MNS 1097:2023 | Нитрат - NO ₃ , мг/л | 200 | 3.7 |
| MNS 1097:2023 | Кальци - Ca, мг/л | 100 | 40.1 |
| MNS 6832:2020 | Гидрокарбонат - HCO ₃ , мг/л | | 113.5 |
| MNS 6835:2020 | Цэвэр - Si, мг/л | | 19.8 |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Ж.Сүлд-Эрдэнэ (нэр)
Хянаж баталгаажуулсан чанарын зөвшөөрөгч: Т.ОЮУНММӨГ (нэр)

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн сорьцонд хамаарна. Шинжилгээний дүнг лабораторийн эвчээрлэлтэй хуулбартай хэрэглэнэ.

Төлбөрийн баримт



